

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэн стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

**Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн
гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр**

Төсвийн ерөнхийлөн захирагч: Аймгийн Засаг дарга

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2024.10.02	A/507	Хөрөнгө зарцуулах тухай	
2	Аймгийн Засаг дарга	2024.10.02	A/511	Хөрөнгө зарцуулах тухай	
3	Аймгийн Засаг дарга	2024.10.02	Б/67	Б.Мөрөндалайд тусламж үзүүлэх тухай	
4	Аймгийн Засаг дарга	2024.10.03	A/514	Дэмжлэг үзүүлэх тухай	
5	Аймгийн Засаг дарга	2024.10.03	A/515	Хөрөнгө зарцуулах тухай	
6	Аймгийн Засаг дарга	2024.10.03	A/516	Хөрөнгө зарцуулах тухай	
7	Аймгийн Засаг дарга	2024.10.15	A/538	Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох тухай	
8	Аймгийн Засаг дарга	2024.10.15	A/539	Хөрөнгө зарцуулах тухай	
9	Аймгийн Засаг дарга	2024.10.16	A/541	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах тухай	
10	Аймгийн Засаг дарга	2024.10.16	A/542	Хөрөнгө зарцуулах тухай	
11	Аймгийн Засаг дарга	2024.10.18	A/544	Хөрөнгө зарцуулах тухай	
12	Аймгийн Засаг дарга	2024.10.18	A/548	Дэмжлэг үзүүлэх тухай	
13	Аймгийн Засаг дарга	2024.10.18	A/550	Хөрөнгө зарцуулах тухай	
14	Аймгийн Засаг дарга	2024.10.18	A/551	Дэмжлэг үзүүлэх тухай	
15	Аймгийн Засаг дарга	2024.10.21	A/554	Хөрөнгө зарцуулах тухай	
16	Аймгийн Засаг дарга	2024.10.21	A/555	Дэмжлэг үзүүлэх тухай	
17	Аймгийн Засаг дарга	2024.10.23	A/561	Хөрөнгө зарцуулах тухай	
18	Аймгийн Засаг дарга	2024.10.23	A/562	Хөрөнгө зарцуулах тухай	
19	Аймгийн Засаг дарга	2024.10.28	A/569	Хөрөнгө зарцуулах тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга



Холбогдох утас: 88089938

И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/569


Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, журам, дүрэм, стандартыг олон нийтэд сурталчлах, аюулгүй орчинд хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндээ хамгаалах дадлыг олгох зорилгоор агентлаг байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулахад 3,945,000 (Гурван сая есөн зуун дөчин таван мянга) төгрөгийг зарцуулсугай.
2. Сургалтыг зохион байгуулахад зарцуулах 3,945,000 (Гурван сая есөн зуун дөчин таван мянга) төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийн бодлого удирдлага хөтөлбөрийн Хөдөлмөрийн хамтын гэрээ хэлэлцээрийг бүртгэж, үйл ажиллагааг дэмжих арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д зөвшөөрсүгэй.
3. Тус чадавхжуулах сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, тайланг хугацаанд нь нэгтгэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/562

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXVIII хуралдааны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн урсгал зардалд хийх тодотголоор Дулааны станцын шайв тохиргооны дутуу санхүүжилтийг шийдвэрлэх зардалд 26,200,000 (Хорин зургаан сая хоёр зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 26,200,000 (Хорин зургаан сая хоёр зуун мянга) төгрөгийг "Барилга хот байгуулалт нийтийн аж ахуйн бодлого хөтөлбөрийн бараа үйлчилгээний бусад зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/561

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 10 сарын 17-ны 25 дугаар хуралдааныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар хуралдаанаар төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажил хангахад зориулж Дулааны станцад нэн шаардлагатай байгаа дизель генератор худалдан авах зардалд 8,300,000 (Найман сая гурван зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 8,300,000 (Найман сая гурван зуун мянган) төгрөгийг "аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө"-өөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/555

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXVIII хуралдааны XXVIII/37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн иргэн, Жудо бөхийн Олон улсын хэмжээний мастер, Дэлхийн 2024 оны аварга, Парис-2024 зуны олимпын мөнгөн медальт тамирчин Бавуудоржийн Баасанхүүгийн анхны багш болох Алтанцэцэгийн Даваадорж, Бямбажавын Очирбат нарт тус бүр 10,000,000 (арван сая) төгрөг, нийт 20,000,000 (хорин сая) төгрөгийг олгосугай.

2.Тус зардлыг аймгийн “Засаг даргын Тамгын газар дансны Нийтийн биеийн тамирын зардал”-аас гаргаж зарцуулахыг ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Дээрх зардлыг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т тус тус даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/554

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит XXVIII хуралдааны XXVIII/37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хүүхдийн “Уран дөш зуслан”-гийн үйл ажиллагааны үндсэн хөрөнгө болон ахуйн бусад материалд шаардагдах зардалд 30,000,000 (гучин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлыг “аймгийн Засаг даргын Тамгын газрын Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого удирдлага хөтөлбөр зориулалт”-аас гаргаж зарцуулахыг ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д үүрэг болгосугай.

3. Хүүхдийн “Уран дөш зуслан”-гийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг үр дүнтэй зарцуулж, мэдээллээр хангаж ажиллахыг хүүхдийн “Уран дөш зуслан” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Шагай), үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011598



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/551

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын Тусгай Олимпын хорооноос оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад урам дэм өгөх, бие бялдрыг нь хөгжүүлэх, нийгэмшүүлэх зорилгоор зохион байгуулагдах Хангайн бүсийн “Боломжийг бүгдэд нь II” арга хэмжээнд аймгаас оролцох багийн зардалд 3,000,000 (Гурван сая) төгрөг, өөрийн гэсэн орон гэргүй гэр олгохыг хүссэн Мөрөн сумын иргэн Ганболдын Мягмарсүрэнд 300,000 (Гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 3,300,000 (Гурван сая гурван зуу мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/550

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит XXVIII хуралдааны 43 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Аймагт эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцаж төгсөөд аймагтаа ирж ажиллах гэрээ байгуулсан нэр бүхий оюутанд хавсралтад зааснаар сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлсүгэй.
- 2.Дээрх зардлын 22,000,000 (хорин хоёр сая) төгрөгийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны төсөвт батлагдсан “Эрх зүй, нийгмийн хэв журам” хөтөлбөрийн “Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт хангах” зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Э.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.
- 3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн АСД-дугаар захирамжийн хавсралт

Дотоодын их, дээд сургуульд:

№	Овог нэрс	Сургууль	Сонгосон мэргэжил	Төлбөрийн хэмжээ Төгрөг	Регистрийн дугаар	Дансны дугаар	Холбоо барих утас хаяг	Тайлбар
1	Даваадорж Төгсбая	ХААИС	Малын эмч	2,500,000	Аав Ц.Даваадорж РЭ85072011	Голомт 1235153264	88525927	Ц.Даваадоржийн дансаар авах 88898669
2	Бямбасүрэн Энхсүрэн	ХААИС	Зоо техникч	2,500,000	РК06211508	ХААН. 5926609797	80930819	ээж
3	Шаравпил Анхбаяр	ХААИС	Зоо техникч	2,500,000	РЛ87120603	ХААН. 5041043268	88093143	
4	Даваахүү Мөнгөнсүх	ШУТИС МХТС	IT инженер	2,500,000	РМ06290813	ХААН. 5219582268	88556121	
		ДҮН		10,000,000				
Буриад Улсын Хөдөө аж ахуйн академид:								
1	Амартүвшин Хишигдорж	Улан-Үдэ ХАА академи	Малын эмч	2,000,000	РЮ05270818	ХААН. 5916762861	80483636	
2	Мөнх-Эрдэнэ Нямтулга	Улан-Үдэ ХАА академи	Малын эмч	2,000,000	Ээж Б.Жаргалсайхан РА88030409	ХААН. 5891043747	88918464	Ээж Б.Жаргалсайханы дансаар авах
3	Мөнгөнсүх Баярмаа	Улан-Үдэ ХАА академи	Малын эмч	2,000,000	РЭ66110901	ХААН. 5926483445	95893279	
4	Ганбаатар Отгонзул	Улан-Үдэ ХАА академи	Малын эмч	2,000,000	РК05232505	ХААН. 5901309791	80795866	
5	Жамъянсүрэн Ганболд	Улан-Үдэ ХАА академи	Малын эмч	2,000,000	Аав С.Жамъянсүрэн РЕ56121571	ХААН. 5896028361	86170458	Аав С.Жамъянсүрэнгийн дансаар авах
6	Баттулга Бумбаяр	Улан-Үдэ ХАА академи	Зоо техникч	2,000,000	РК08272118	ХААН 5901331909	98982519	Ээж Сайнбаяр
		ДҮН		12,000,000				
		НИЙТ ДҮН		22,000,000				





МОНГОЛ УЛС
 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/548

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эмчилгээний зардал хүссэн Б.Батчулуун, А.Мөнхцэцэг, А.Нарантуяа, Г.Бямбарагчаа, А.Эрдэнэбилэг, Г.Бүжинлхам нарт тус бүр 500.000 (Таван зуун мянга), Энэрэл өрхийн эрүүл мэндийн шинэ барилгын нээлтийн арга хэмжээнд 500,000 (Таван зуун мянга) төгрөг, Бүгд найрамдах Солонгос улсаас ирсэн төлөөлөгчдийн уулзалт ярилцлага арга хэмжээнд зарцуулагдах 750,000 (Долоон зуун тавин мянга) төгрөг, үерийн голомтот эцсийн халдваргүйтгэл хийхэд зарцуулагдсан 2,000.000 (Хоёр сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Дээрх зардлын 6,250.000 (Зургаан сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



**МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/544

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.7, 23.1.11 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XXIII хуралдааны 04 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны А/682 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оны Монголд Зочлох жил болгон зарласантай холбогдуулан гадаадын болон дотоодын аялагч жуулчдад орон нутгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах зорилгоор “Ай Ти Эм” олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцоход 5.000.000 (Таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 5.000.000 (Таван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын Газрын төсөвт батлагдсан “Эрх зүй нийгмийн хэв журмын хөтөлбөр”-ийн “Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах” арга хэмжээний зардал – аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Э.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/542

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14.02,41.2.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цахим хөгжил инновац,харилцаа холбооны сайд, Аймгийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цахим орчинд зөв байя 3-р аян Улсын хэмжээнд эхэлсний дагуу Хөвсгөл аймагт ажиллах Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвөөс хамтран зохион байгуулж буй Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх хамтарсан багийн Хөвсгөл аймагт ажиллах томилолтын зардал 1,608,880 (Нэг сая зургаан зуун найман мянга найман зуун наян төгрөг)“Цахимд зөв байя” 3 дугаар шатны сургалтыг Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, аймаг, сумдын Төрийн албан хаагчид, иргэдэд зохион байгуулах арга хэмжээний зардалд 6,291,000 (арван долоон сая есөн зуун хорин нэгэн мянга зургаан зуун тавин)төгрөгийг,Аймгийн Веб сайт хөгжүүлэлтэд 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.“Цахим орчинд зөв байя” аяны зардалд Төрийн албаны ерөнхий удирдлага зохицуулалт хөтөлбөрийн Цахим аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд мэдээллийн аюулгүй байдлын үзүүлэлт сайжруулахаас 7,900,000 (Долоон сая есөн зуун мянга) төгрөгийг, Цахим аймаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Веб сайт хөгжүүлэх зардлаас 10,000,000 (Арван сая) төгрөгийг зарцуулахыг нягтлан бодогч (Э.Анхцэцэг) -д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/541

Мөрөн сум

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох
сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн ээлжит XXVIII хуралдааны 37 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүүхэд хөгжил, хамгааллыг дэмжих жил"-ийн хүрээнд Мөрөн сумын ерөнхий боловсролын сургуулиудын багш нар болон эцэг эхчүүдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт зарцуулагдах 10,100,000 (арван сая нэг зуун мянга) төгрөгийг "Хүүхэд хөгжил хамгааллыг дэмжих жил" нэрлэсэн жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Э.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/539

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын Хөвсгөл салбараас ирүүлсэн хүсэлтийн дагуу үйл ажиллагааны зардалд 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагааны зардал 4,000,000 (Дөрвөн сая) төгрөгийг Эрх зүйн нийгмийн хэв журам хөтөлбөрийн Засаг даргад хуулиар олгогдсон үүрэг эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах зардлаас шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/538

Мөрөн сум

Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7, 51 дүгээр зүйлийн 51.3, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн байгууллагуудын төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад таван жил тутамд нэг удаа олгох урамшууллын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Мөнгөн урамшуулалд олгох зардлыг төрийн албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж тусламжийн зардлаас шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3.Холбогдох хууль, тогтоол журмын дагуу холбогдох баримт материалын бүрдлийг бүрэн зөв хангаж ажиллахыг төсөв захирагч нарт даалгасугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д даалгасугай.


ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 он
/с дугаар сарын /с-ний өдрийн
А/с дугаар захирамжийн
хавсралт



Төрийн захиргааны албан хаагчдад олгох мөнгөн
урамшууллын жагсаалт /сум, байгууллагаар/

(мян.төгрөг)

№	Байгууллага	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Худалдан авах ажиллагааны газар	1	6,875.0
2	Алаг-Эрдэнэ сумын ЗДТГ	1	6,765.0
3	Түнэл сумын ЗДТГ	1	6,875.0
Нийт дүн		3	20,515.0



МОНГОЛ УЛС
 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/С/16

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дугаар заалт, Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдааны 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 24 тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

- 1.Хөвсгөл аймаг болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Дэжон хотын Со дүүргийн хооронд байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийг хангах, аймаг орон нутгийн онцлог, үндэсний урлаг соёлоо олон улсад сурталчлах зорилгоор “Дэжон Урлагийн фестиваль 2024”-д оролцох урлагийн бүрэлдэхүүнд 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.
- 2.Тус зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын “Эрх зүй нийгмийн хэв журам” хөтөлбөрийн “Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд зарцуулах” арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.
- 3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/575

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 35 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 24 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дотоодын цэргийн 835 дугаар тусгай салбарын үйл ажиллагааны урсгал зардалд 7,500.000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх 7.500.000 (долоон сая таван зуун мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/574

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 24 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон Улсын олимпиадад оролцоход дэмжлэг хүссэн иргэн И.Сайханбаярт, 500.000 (Таван зуун мянга), Аэробикийн олон улсын тэмцээнд оролцох эх авсан 1 дасгалжуулагч, 10 хүүхдийн замын зардалд дэмжлэг хүссэн багш Н.Мандахцэцэгээр ахлуулсан багт 3,000.000 (гурван сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 3,500.000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ





МОНГОЛ УЛС
 ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 6/67

Мөрөн сум

Б.Мөрөндалайд тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Аймгийн засаг даргын зөвлөлийн хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 22 дугаар тэмдэглэлийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын офицер Б.Мөрөндалайгийн өөрийн амьдарч байгаа хувийн сууцанд 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдөр гал гарч хохирол учирсан тул 1,000,000 (нэг сая) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.
- 2.Тус тусламжийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д зөвшөөрсүгэй.
- 3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Р.Базар)-т даалгасугай.

ДАРГА



[Handwritten signature]

П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/С/11

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 23 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Статистикийн алба байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд “Салбарын шинэчлэлийг орон нутгийн албан хаагчид, мэдээлэгч байгууллагуудад танилцуулах нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн хөтөлбөрт оролцогчдын цайны завсарлагааны зардалд 1,000,000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээр зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. “Салбарын шинэчлэлийг орон нутгийн албан хаагчид, мэдээлэгч байгууллагуудад танилцуулах нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг удирдан зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Статистикийн хэлтсийн дарга (Б.Базардамбуу)-д даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712011484



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/507

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Аялал жуулчлалын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.7, 23.1.11 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ны ээлжит XXIII хуралдааны 04 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2023 оны А/682 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оны Монголд Зочлох жил болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор уламжлалт болгон зохион байгуулдаг “Цаатан фестиваль” аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулахад 5,000.000 (Таван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 5,000.000 (Таван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын Газрын төсөвт батлагдсан “Эрх зүй нийгмийн хэв журмын хөтөлбөр”-ийн “Засаг даргад хуулиар олгосон үүрэг, эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулах, мөн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах” арга хэмжээний зардал—аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Э.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ